



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/373

Улаанбаатар хот

Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/821 дүгээр захирамжийг үндэслэн ТУШААХ нь:


1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 19,500,000.0 /арван есөн сая таван зуун мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хьюндай аксент маркийн 02-37 УБҮ улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс /П.Энхбаяр/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс /П.Энхбаяр/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга Д.Төмөрбаатарт тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

ШҮНЭНБАТ



115050000903